



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/55

Алтрага

Мал эмнэлгийн хаврын төлөвлөгөөт
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн хаврын арга хэмжээний гүйцэтгэх ажлын төрөл, хийж гүйцэтгэх хугацаа, хариуцан ажиллах малын эмч нарын ажил үйлчилгээний хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Уг төлөвлөгөөт арга хэмжээг хуваарийн дагуу товлосон хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхийг "Чанартай сүрэг" ХХК-ийн захирал Л.Дүүжий, "Агар Мөрөн ЭНТ" хоршооны дарга Б.Тунгалагтуул нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү төлөвлөгөөт арга хэмжээний мэргэжлийн төлөвлөлтийг тархварзүйн судалгааны дагуу зохион явуулж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгч ажиллахыг тархварзүйч (Д.Энхтайван)-д үүрэг болгосугай.

4. Мал эмнэлгийн хаврын төлөвлөгөөт арга хэмжээг зохион явуулах ажилд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010132